

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 6 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны гуравдугаар сарын 21-ний 16 цаг 08 минутад эхэлж, 10 цаг 05 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Дэрэн, Говь-Угтаал сумын сургууль, Өлзийт, Луус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Дэрэн сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Дадьсүрэн овогтой Мөнхтогтох 76,83 оноогоор, Говь-Угтаал сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Батсугир овогтой Оюунтөгс 70,84 оноогоор тус тус тэнцэж, тухайн ажлын байруудад тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангасан тул тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэхийг Боловсрол, соёлын газар /Ц.Бумангэрэл/-т зөвшөөрсөн шийдвэр гаргаж хүргүүлэхээр болов.
2	Ц.Идэр-Оргилын өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	“Ц.Идэр-Оргилыг ажлаас чөлөөлөх тухай” аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны 01 сарын 23-ны өдрийн Б/01 тоот тушаалыг эс зөвшөөрч Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажил зуучлал хариуцсан мэргэжилтнээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн гомдлыг хянан шалгасан Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж, зөвлөмж шийдвэрийг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, Ц.Идэр-Оргил нарт хүргүүлэхээр болов.
3	Х.Мөнхсаруулын өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	“Х.Мөнхсаруулыг ажлаас чөлөөлөх тухай” аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2017 оны 02 сарын 06-ны өдрийн Б/16 тоот тушаалыг эс зөвшөөрч тус газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Х.Мөнхсаруулын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн гомдлыг хянан шалгасан Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж, зөвлөмж шийдвэрийг Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Х.Мөнхсаруул нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.
4	Оны шилдэг менежер шалгаруулах тухай	Сумын Засаг даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээгээ амжилттай биелүүлж, аймгийн шилдэг менежерийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Сэмжаан овогтой Мятагмаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Ням-Очир овогтой Гантулга нарыг аймгийн “Шилдэг менежер”-ээр шалгаруулж, шагнахаар болов.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА